



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 11 өдөр

Дугаар А/181

Номгон

Удирдах ажилтны шуурхай мэдээлэл хийх  
журам батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6.л заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Удирдах ажилтнуудын шуурхай мэдээллийн цагийн журмыг хавсралтаар баталсугай.

2.Удирдах ажилтнуудын шуурхай мэдээллийн цагт аймгийн төвийн байгууллагын дарга, удирдах ажилтнууд танхимаар, сумын Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын болон төсөвт байгууллагын дарга, захирал, эрхлэгч нар цахим хэлбэрээр байнга оролцож бодлого шийдвэрийн мэдээллээр хангагдаж, түгээж ажиллахыг нийт удирдах албан тушаалтнуудад үүрэг болгосугай.

3.Ерөнхийлөгчийн Тамгын газар, Улсын Их хурал, Засгийн газар, аймаг орон нутгийн удирдлагын иргэдтэй хийгдэх уулзалт мэдээлэлд удирдах болон гүйцэтгэх ажилтнуудаа бүрэн оролцуулах, мэдээллийг иргэдэд түгээж сурталчилж ажиллахыг байгууллагуудын удирдлагад үүрэг болгосугай.

4.Удирдах ажилтнуудын шуурхай мэдээллийн цагийг ажил хэрэгч зохион байгуулж бүртгэл, тэмдэглэлээр үүргийг албажуулан, ирц, үр дүнг тогтмол танилцуулан, хариуцлага тооцож ажиллахыг Төрийн захиргааны, удирдлагын хэлтэс (Ж.Алтанцэцэг)-т, захирамж, журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (М.Өнөржаргал)-т тус тус үүрэг болгосугай

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

1210537

Аймгийн Засаг даргын 2021 оны 03 дугаар  
сарын 11-ний өдрийн А/181 дүгээр захирамжийн  
хавсралт



## **АЙМГИЙН УДИРДАХ АЖИЛТНУУДЫН ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨНИЙ ЖУРАМ**

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Энэхүү журмын зорилго нь аймгийн Нутгийн захиргааны байгууллагуудын удирдлагын хариуцлагыг өндөржүүлэх, цаг үеийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх, аймгийн удирдлагаас өгсөн үүрэг, даалгаврын хэрэгжилтийг эрчимжүүлэх, байгууллага хоорондын ажлын уялдаа холбоог сайжруулахад чиглэсэн шуурхай мэдээлэл /цаашид “шуурхай мэдээллийн цаг” гэх/-ийг зохион байгуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн удирдах ажилтнууд энэхүү журмын дагуу шуурхай мэдээлэлд оролцоно.

1.3. Аймгийн Засаг даргын захирамжаар батлагдсан шуурхай мэдээлэлд оролцох удирдах албан тушаалтнуудын нэрсийн жагсаалтад заасан албан тушаалтнууд заавал оролцоно.

1.4. Нэгдсэн зөвлөгөөнд сумын Засаг дарга, Тамгын газрын дарга, төсөвт байгууллагын дарга эрхлэгч нар цахим болон хосолмол хэлбэрээр заавал оролцож мэдээ мэдээлэл солилцох, асуулт асуух, хариулт авах тохиолдолд боломжит хэлбэрийг сонгоно.

### **Хоёр. Шуурхай мэдээллийн цагийг зохион байгуулах**

2.1. Шуурхай мэдээллийн цагийг аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд долоо хоног бүрийн Мягмар гарагийн 16.00-18.00 цагт зохион байгуулна.

2.2. Шуурхай мэдээллийн цагийн байрны нөхцөл, техник хэрэгслийн бэлэн байдлыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийтлэг үйлчилгээний алба хариуцна.

2.3. Аймгийн Засаг даргаас өгсөн үүргийн биелэлтийг Мягмар гаргийн 15.00 цагаас өмнө, шуурхай мэдээллийн цагт тавих илтгэл, мэдээлэл, танилцуулга зэргийг цахим хэлбэрээр бэлтгэн шуурхай мэдээлэл болохоос нэг өдрийн аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны, удирдлагын хэлтэст ирүүлнэ.

## 2.

2.4.Тухайн өдрийн шуурхай мэдээллийн цагаас өгсөн үүрэг даалгавар, өмнөх шуурхай мэдээллийн цагийн үүрэг даалгаврын биелэлтийг Төрийн захиргаа удирдлагын хэлтсийн хэвлэлийн ажилтан ажлын 1 хоногт багтаан аймгийн цахим хуудсанд байршуулна.

2.5.Шуурхай мэдээллийн цагийн тэмдэглэлийг Төрийн захиргааны, удирдлагын хэлтсийн мэргэжилтэн хөтөлж, тэмдэглэлийг ажлын 3 хоногт багтаан Засаг даргын Тамгын газрын даргаар гарын үсэг зуруулж, албажуулан холбогдох албан тушаалтныг үүрэгжүүлнэ.

### **Гурав. Шуурхай мэдээллийн цагийг явуулах**

3.1.Шуурхай мэдээллийн цагийг аймгийн Засаг дарга, түүний эзгүйд Засаг даргын орлогч удирдан явуулна.

3.2.Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн шуурхай мэдээллийн цагт оролцогчдын ирцийг бүртгэж, тэмдэглэл хөтлөн, Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга үүрэгжүүлэн, биелэлтэд хяналт тавина.

3.3.Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга шуурхай мэдээллийн цаг дээр өгөгдсөн үүрэг, даалгаврын хэрэгжилтийг дараагийн мэдээллийн цагт тогтмол мэдээлнэ.

### **Дөрөв. Шуурхай мэдээллийн цагт оролцох албан тушаалтан**

#### **4.1.Танхимаар олцох албан тушаалтнууд**

4.1.1.Аймгийн Засаг даргын Тамгын газрын хэлтэс, штаб, тасгийн дарга нар

4.1.2.Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэрэгжүүлэгч агентлагийн дарга нар

4.1.3.Аймгийн хэмжээний төсөвт байгууллагын дарга, орон нутгийн өмчит байгууллагуудын дарга нар

4.1.4. Баянхонгор сумын Засаг дарга, Тамгын газрын дарга болон төсөвт байгууллагуудын дарга, захирал, эрхлэгч нар

#### **4.2. Цахимаар оролцох албан тушаалтнууд**

4.2.1.Сумдын Засаг дарга, Тамгын газрын дарга нар болон төсөвт байгууллагуудын дарга, захирал, эрхлэгч нар

### **Тав.Шуурхай мэдээллийн цагаар хэлэлцэх асуудал**

5.1.Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга шинээр гарсан аймгийн ИТХ-ын болон Тэргүүлэгчдийн тогтоол, аймгийн Засаг даргын захирамж, албан даалгавар, Засгийн газрын хууль тогтоомжийн мэдээлэл /8-10 минут/

### 3.

5.2.Тухайн сард гарсан гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал, байгууллагын үндсэн чиг үүргийн хүрээнд хийсэн ажил, цаг үеийн тулгамдаж байгаа асуудал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар аймгийн Цагдаагийн газрын мэдээлэл /5-8 минут/

5.3.Тухайн сард аймгийн хэмжээнд гарсан гамшиг осол, зөрчлийн нөхцөл байдал, байгууллагын үндсэн чиг үүргийн хүрээнд хийсэн ажил, цаг үеийн тулгамдаж байгаа асуудал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар аймгийн Онцгой байдлын газрын мэдээлэл /5-8 минут/

5.4.Тухайн сард аймгийн хэмжээнд зохион байгуулсан хяналт, шалгалтын ажил, гарсан зөрчлийн нөхцөл байдал, байгууллагын үндсэн чиг үүргийн хүрээнд хийсэн ажил, цаг үеийн тулгамдаж байгаа асуудал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар аймгийн Мэргэжлийн хяналтын газрын мэдээлэл /5-8 минут/

5.5.Тухайн сард аймгийн хэмжээний өвчлөл, эндэгдэл, эрүүл мэндийн талаарх мэдээлэл болон байгууллагын үндсэн чиг үүргийн хүрээнд хийсэн ажил, цаг үеийн тулгамдаж байгаа асуудал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар аймгийн Эрүүл мэндийн газрын мэдээлэл /5-8 минут/

5.6.Цаг үеийн шаардлагаар шуурхай мэдээллийн цагт мэдээлэл хийх албан тушаалтан мэдээллээ урьдчилан танилцуулна.

5.7.Шуурхай мэдээллийн цагт тавих мэдээлэл, танилцуулга нь товч тодорхой бөгөөд цахим хэлбэрээр бэлтгэгдсэн байна.

5.8.Аймгийн Засаг дарга шуурхай мэдээллийн цагийг дүгнэж, цаашид хийж гүйцэтгэх ажлын талаар үүрэг даалгавар өгнө.

**Зургаа.Шуурхай мэдээллийн цагт оролцогсдын хүлээх үүрэг, хариуцлага**

6.1.Шуурхай мэдээллийн цагт оролцогч удирдах ажилтнууд нь аймгийн Засаг даргаас өгсөн үүрэг, даалгаврын хэрэгжилтийг аймгийн Засаг даргын өмнө биечлэн хариуцна.

6.2.Шуурхай мэдээллийн цагт мэдээлэл өгөгч нь тухайн асуудлаар олгогдсон хугацаанд чанартай, товч, үнэн бодит мэдээлэл бэлтгэн оролцох сарын шуурхай зөвлөгөөнөөс 2 хоногийн өмнө Төрийн захиргааны, удирдлагын хэлтэст танилцуулж хөтөлбөрт оруулсан байна.

6.3.Шуурхай мэдээллийн цагт зөвхөн нийтийг хамарсан асуудлаар санал тавьж, асуудал дэвшүүлнэ.

4.

6.4. Шуурхай мэдээллийн цагт оролцогч албан тушаалтан мэдээллийн цагийн үеэр өгсөн үүрэг, даалгавар, мэдээ мэдээллийг өөрийн байгууллагын хамт олонд ажлын 8 цагийн дотор мэдээлж, ажил хариуцан гүйцэтгэх албан тушаалтнуудыг үүрэгжүүлнэ.

6.5. Шуурхай мэдээллийн цагт ээлжийн амралттай, өвчтэй, чөлөөтэй, томилолттой зэрэг хүндэтгэн үзэх шалтгаантайгаас бусад тохиолдолд байгууллагын дарга заавал оролцоно.

6.6 Шуурхай мэдээллийн цагт оролцох албан тушаалтан хүндэтгэн үзэх шалтгаанаар оролцож чадахгүй тохиолдолд аймгийн Засаг даргын Тамгын газрын даргаас чөлөө авч, албан ёсны төлөөллөө оролцуулан ирцийн бүртгэлд бүртгүүлнэ. Чөлөө аваагүй тохиолдолд орлон ирсэн албан тушаалтныг тухайн шуурхай мэдээллийн цагт оролцуулахгүй.

6.7 Шуурхай мэдээллийн цагийг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр 3-аас дээш удаа тасалсан, шуурхай мэдээллийн цагийн үеэр өгсөн үүрэг, даалгаврыг хугацаанд нь биелүүлээгүй албан тушаалтанд Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулна.

6.8. Батлагдсан журамтай биечлэн танилцаж гарын үсэг зурснаар бүх албан тушаалтны үүрэг хариуцлага эхэлнэ.

**ШУУРХАЙ МЭДЭЭЛЛИЙН ЦАГТ ОРОЛЦОХ  
УДИРДАХ АЖИЛТНУУД**

№	Байгууллага	Албан тушаал
1	2	3
1	Аймгийн Засаг даргын тамгын газар	Аймгийн Засаг даргын орлогч
2	Аймгийн ИТХурал	Аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга
3	Аймгийн Засаг даргын Тамгын газар	Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга
4	Аймгийн Засаг даргын Тамгын газар	Төрийн захиргаа удирдлагын хэлтсийн дарга
5	Аймгийн Засаг даргын Тамгын газар	Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга
6	Аймгийн Засаг даргын Тамгын газар	Хууль зүйн хэлтсийн дарга
7	Аймгийн Засаг даргын Тамгын газар	Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
8	Аймгийн Засаг даргын Тамгын газар	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс
9	Аймгийн Засаг даргын Тамгын газар	Хяналт-шинжилгээ үнэлгээний тасгийн дарга
10	Аймгийн Засаг даргын Тамгын газар	Цэргийн штабын дарга
11	Аймгийн Засаг даргын Тамгын газар	Архивын тасгийн дарга
12	Байгаль орчин, аялал жуулчлалын газар	Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга
13	Биеийн тамир, спортын газар	Биеийн тамир, спортын газрын дарга
14	Боловсрол, соёл, урлагийн газар	Боловсрол, соёл, урлагийн газрын дарга
15	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга
16	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга
17	Мэргэжлийн хяналтын газар	Мэргэжлийн хяналтын газрын дарга
18	Онцгой байдлын газар	Онцгой байдлын газрын дарга
19	Орон нутгийн өмчийн газар	Орон нутгийн өмчийн газрын дарга
20	Санхүүгийн хяналт, аудитын алба	Санхүүгийн хяналт, аудитын албаны дарга
21	Стандарт, хэмжил зүйн хэлтэс	Стандарт, хэмжил зүйн хэлтсийн дарга
22	Статистикийн хэлтэс	Статистикийн хэлтсийн дарга
23	Татварын хэлтэс	Татварын хэлтсийн дарга
24	Улсын бүртгэлийн хэлтэс	Улсын бүртгэлийн хэлтсийн дарга
25	Ус, цаг уур, орчны шинжилгээний төв	Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн дарга
26	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга
27	Хүнс, хөдөө аж ахуйн газар	Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга
28	Цагдаагийн газар	Цагдаагийн газрын дарга

1	2	3
29	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын дарга
30	Шүүхийн шинжилгээний алба	Шүүхийн шинжилгээний албаны дарга
31	Эрүүл мэндийн газар	Эрүүл мэндийн газрын дарга
32	Нийгмийн даатгалын хэлтэс	Нийгмийн даатгалын хэлтсийн дарга
33	Эрүүл мэндийн даатгалын хэлтэс	Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн дарга
34	Мал эмнэлгийн газар	Мал эмнэлгийн газрын дарга
35	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга
36	Авто тээврийн төв	Авто тээврийн төвийн дарга
37	Нэгдсэн эмнэлэг	Нэгдсэн эмнэлгийн ерөнхий эмч
38	Зооноз өвчин судлалын төв	Зооноз өвчин судлалын төвийн дарга
39	Зэвсэгт хүчний 339-р анги	Зэвсэгт хүчний 339-р ангийн захирагч
40	Хөгжимт драмын театр	Хөгжимт драмын театрын дарга
41	Аймгийн Музей	Музейн дарга
42	Нийтийн номын сан	Нийтийн номын сангийн захирал
43	Хүүхдийн тэмүжин театр	Хүүхдийн Тэмүжин театрын дарга
44	Их богдын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа	Их богдын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны дарга
45	Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргаа	Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргааны дарга
46	Улсын нөөцийн газар	Улсын нөөцийн газрын дарга
47	Сум дундын Ойн анги	Сум дундын Ойн ангийн дарга
48	Холбооны газар	Холбооны газрын дарга
49	Мэдээлэл холбооны сүлжээ ХХК	Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн дарга
50	Шуудан үйлчилгээний газар	Шуудан үйлчилгээний газрын дарга
51	"Баянхонгор-Эрчим хүч" ЦТХХК	"Баянхонгор-Эрчим хүч" ЦТХХК-ийн дарга
52	"Чандмань-Баянхонгор" ХК	"Чандмань-Баянхонгор" ХК-ний захирал
53	"Цэвэр хот" ОНӨААТҮГ-ийн газар	"Цэвэр хот" ОНӨААТҮГ-ын дарга
54	Баянхонгор тохижилт үйлчилгээ	Баянхонгор тохижилт үйлчилгээний газрын дарга
55	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн холбоо ТББ	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн холбоо ТББ-ын тэргүүн
56	Нисэх буудал	Баянхонгор аймагдахь Нисэх буудлын дарга
57	Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газар	Баянхонгор сумын Засаг дарга
58	Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газар	Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газрын дарга
59	Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газар	1 дүгээр багийн дарга
60	Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газар	2 дугаар багийн дарга
61	Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газар	3 дугаар багийн дарга

1	2	3
62	Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газар	4 дүгээр багийн дарга
63	Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газар	5 дугаар багийн дарга
64	Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газар	6 дугаар багийн дарга
65	Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газар	7 дугаар багийн дарга
66	Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газар	9 дүгээр багийн дарга
67	Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газар	10 дугаар багийн дарга
68	Улаан загалмайн хороо	Дарга
69	Нэг цэгийн үйлчилгээний төв	Төвийн дарга
70	Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци	Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпорацийн захирал
71	Монгол банк	Захирал
72	Номундалай лаборатори сургууль	Захирал
73	Номгон ахлах сургууль	Захирал
74	Эрдэнэмандал ахлах сургууль	Захирал
75	Эрдэм ахлах сургууль	Захирал
76	Соого сейкео сургууль	Захирал
77	Политехникийн коллеж	Захирал
78	Өлзийт МСҮТ	Захирал
79	Баян-Ойт цогцолбор сургууль	Захирал
80	2-р цэцэрлэг	Эрхлэгч
81	3-р цэцэрлэг	Эрхлэгч
82	4-р цэцэрлэг	Эрхлэгч
83	5-р цэцэрлэг	Эрхлэгч
84	6-р цэцэрлэг	Эрхлэгч
85	7-р цэцэрлэг	Эрхлэгч
86	9-р цэцэрлэг	Эрхлэгч
87	10-р цэцэрлэг	Эрхлэгч
88	11-р цэцэрлэг	Эрхлэгч
89	12-р цэцэрлэг	Эрхлэгч
90	13-р цэцэрлэг	Эрхлэгч
91	14-р цэцэрлэг	Эрхлэгч
92	15-р цэцэрлэг	Эрхлэгч
93	16-р цэцэрлэг	Эрхлэгч
94	1-р багийн өрхийн эрүүл мэндийн төв	Өрхийн эмч
95	2-р багийн өрхийн эрүүл мэндийн төв	Өрхийн эмч
96	3-р багийн өрхийн эрүүл мэндийн төв	Өрхийн эмч
97	4-р багийн өрхийн эрүүл мэндийн төв	Өрхийн эмч
98	5-р багийн өрхийн эрүүл мэндийн төв	Өрхийн эмч
99	6-р багийн өрхийн эрүүл мэндийн төв	Өрхийн эмч
100	7-р багийн өрхийн эрүүл мэндийн төв	Өрхийн эмч
101	9-р багийн өрхийн эрүүл мэндийн төв	Өрхийн эмч
102	10-р багийн өрхийн эрүүл мэндийн төв	Өрхийн эмч



4.

1	2	3
103	Сумдын Засаг дарга, ИТХ-ын дарга, төсвийн байгууллагын дарга, эрхлэгч багийн Засаг дарга нар	Сумдын Засаг дарга, ИТХ-ын дарга, төсвийн байгууллагын дарга, эрхлэгч багийн Засаг дарга нар

\_\_\_\_\_оОо\_\_\_\_\_